

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2026 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН БАЙДЛААРХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

2026 оны 03 дугаар сарын 11

Улаанбаатар хот

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн Дотоод аудитын албаны үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах, тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийг бодит мэдээллээр ханган шалгагдсан байгууллагын төсвийн эрх захирагч, санхүү бүртгэлийн ажилтнуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр зөвлөн туслах, санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг гүйцэтгэн, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Тус алба нь 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар батлагдсан орон тоогоор 8.5 хүний бүрэлдэхүүнтэй нийт 488 хүн өдөр ажиллахаас нийт 488 хүн өдөр ажиллаж санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын чиглэлээр хяналт шалгалтыг гүйцэтгэлээ.

Хяналт шалгалтын ажлын талаар:

Төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд дүүргийн Засаг даргын баталсан 2026 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2026 онд 50 байгууллагад төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг хийхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 18 байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалтыг гүйцэтгэн ажиллаж байна.

Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан 2026 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө, СХШУТ/2026-01 дугаар удирдамжийн хүрээнд Буянт манал, Жаргал-Өлзий, Мичид ундарга, Санхум, Отгон долоон бурхан, Анан, Наранманал, Байгаль наран, Алтанцэгцүүхэй, Ээлтэй, Баянбигэр, Тонэ, Жаргалант тосгоны Эрүүл мэндийн төв зэрэг нийт 13 байгууллагын 2025 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд, СХШУТ/2026-02 дугаар удирдамжийн хүрээнд ерөнхий боловсролын 12,42,76,105,122 дугаар сургуулиудын 2024 оны жилийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан талаар:

Сонгинохайрхан төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний болон харъяа нийт 117 байгууллага (орон нутгийн байгууллага 12, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 3, сургууль 29, Насан туршийн суралцахуйн төв 1, цэцэрлэг 71, Хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төв 1), төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж буй 26 өрхийн эрүүл мэндийн төв, нийт 143 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд сар, улирлаар хяналт шалгалтыг гүйцэтгэн, 2025 оны 1, 2, 3, 4 дүгээр улирлын хяналт шалгалтын тайланг төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж ажиллалаа.

Дүүргийн Дотоод аудитын хорооны үйл ажиллагаа:

Дүүргийн Аудитын хороо нь дүүргийн Засаг даргын 2013 оны 182 дугаар захирамжаар аудитын хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг баталсан бөгөөд дүүргийн Засаг даргын 2025 оны А/620 дугаар захирамжаар нийт 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулагдсан. Аудитын хорооны хурлаар дүүргийн Дотоод аудитын албаны төлөвлөгөөг батлах, тайланг сонсох, шалгалтын дүнг хэлэлцэн шийдвэр гаргах зэрэг үйл ажиллагааг явуулж байна. Дотоод аудитын хорооны 2026 оны үйл ажиллагааг хорооны гишүүдэд танилцуулан Хорооны төлөвлөгөөг баталгаажуулан ажиллаж байна.

Сургалтын үйл ажиллагааны талаар:

Сонгинохайрхан дүүргийн Дотоод аудитын албаны сургалтын хөтөлбөр, 2026 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөг тус албаны даргаар батлуулан биелэлтийг ханган ажиллаж байна.


Албаны сургалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулахдаа тус албаны дотоод аудиторуд, албан хаагчдаас дараах чиглэлээр санал авч тусгасан болно. Үүнд:

1. Албан хаагчдын эрх зүй, эрүүл мэнд
2. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх
3. Төрийн байгууллага бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зэрэг болно.

Албаны сургалтын нэгдсэн төлөвлөгөөг 2026 онд нийт 3 зорилт 9 арга хэмжээний хүрээнд зохион байгуулахаар боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар дээд шатны байгууллагаас зохион байгуулсан 2 сургалтад 2 албан хаагч хамрагдсан байна. Үүнд:

1.Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Нийслэлийн дүүрэг болон дүүргийн харьяа байгууллагуудын мэдээллийн ил тод байдал хариуцсан албан хаагчдад зориулсан “Төрийн цахим үйлчилгээний системд нээлттэй мэдээлэл байршуулах, тайлан илгээх” арга зүйн сургалтад тус албаны ахлах дотоод аудитор Г.Энхзул хамрагдсан.

2026 оны 03 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулагдсан дүүргийн Жендэрийн



салбар хороо, дэд салбар хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтад тус албаны дотоод аудитор Д.Гэрэлт-Од хамрагдсан байна.

Дотоод ажлын талаар: 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар тус албаны цахим хуудсаар дүүргийн хэмжээнд зохион байгуулагдсан шинэ шинэлэг мэдээ, мэдээлэл дүүргийн цахим хуудсаар дамжин хүргэгддэг тухайн өдрийн онцлох үйл явдлын болон дүүргийн хороодын хог ачилтын хуваарь бусад алба хэлтсээс зохион байгуулж буй ажил үйлчилгээний зарлал, аяны мэдээллүүд зэрэг 93 нэр төрлийн мэдээ, фостер, реел, богино хэмжээний бичлэг зурган мэдээллийг бэлтгэн байршуулж тухайн онд шинэчлэгдэн мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, түүний өөрчлөлт, бусад алба хэлтсээс зохион байгуулагдсан үйл ажиллагааны цаг үеийн мэдээ мэдээллийг шэйр хийн албаны цахим хуудсаар түгээн дэлгэрүүлэн ажиллалаа.

Тус албанд 2026 оны 1 дүгээр улиралд албан хэрэг хөтлөлтийн edoc.ulaanbaatar.mn цахим системээр ирсэн бичиг 71 үүнээс хариутай албан бичиг 8, албан бичгийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 1,40 %-тай, баримт бичгийн эргэлтийн мэдээг сар бүр гарган ажиллаж байна.Байгууллагаас нийт 16 бичгийг боловсруулан крилл, монгол бичгээр хөрвүүлэн холбогдох байгууллагуудад явуулсан.2026 оны 1 дүгээр улирлын байдлаар албанд өргөдөл хүсэлт гаргаагүй байна.

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнд хуваарийн дагуу оролцож өгөгдсөн мэдээлэл, үүрэг даалгаврыг албан хаагчдад танилцуулан үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр гаргаж холбогдох хэлтэст хүргүүлэн, албаны шуурхай хурлыг 6 удаа зохион байгуулан ажиллалаа.

ТОВЧ ТАЙЛАН БИЧСЭН:
АХЛАХ ДОТООД АУДИТОР

Ш.БОЛОРМАА